

**Монгол Улсын Эрчим хүчний яам
Улаанбаатар хотын дулаан хангамжийн салбарыг
сайжруулах төсөл
P170676**

**Төсөл
БАЙГАЛЬ ОРЧНЫ БА НИЙГМИЙН УДИРДЛАГЫН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
(ESCP)**

2019 оны 11-р сар

БАЙГАЛЬ ОРЧНЫ БА НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Монгол Улсын Сангийн яам, Эрчим хүчний яам болон Улаанбаатар дулааны сүлжээ ХК хамтран “Улаанбаатар хотын дулаан хангамжийн салбарыг сайжруулах төсөл”-ийг (цаашид **Төсөл** гэнэ) хэрэгжүүлнэ. Тус төсөлд *Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк/Олон улсын хөгжлийн ассоциац* (цаашид **Банк** гэнэ) санхүүжилт олгохыг зөвшөөрсөн.
2. Төслийг Байгаль орчин, нийгмийн ажлуудын стандарттай (ESSs) уялдуулан хэрэгжүүлэх үүднээс Монгол Улс бараа материалын нийлүүлэлт, хэмжилтийн ажлыг хариуцна. Энэхүү *Байгаль орчны ба нийгмийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд (ESCP)* дээрхи стандартын дагуу бараа материалын нийлүүлэлт, хэмжилтийн ажил тус бүрд шаардагдах бичиг баримт, төлөвлөгөө, цаг хугацааг тусгасан байна.
3. Түүнчлэн энэхүү **ESCP**-д дурдсанаар ESF-ийн (Байгаль орчин, нийгмийн хүрээ) бусад E&S (Байгаль орчин, нийгмийн)-ийн баримт бичгүүдэд тусгасан шаардлагыг Төслийн Удирдах нэгж дагаж мөрдөнө. Энэ нь байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдэд тусгасан цаг хугацааны дараалал ба үүнд дараах төлөвлөгөөнүүд багтана.
 - Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (ESMP)
 - Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (RP)
 - Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (ESMF)
 - Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ (RPF)
 - Хөдөлмөрийн удирдлагын журам (LMP)
 - Оролцогч талуудын хариуцах ажлуудын төлөвлөгөө (SEP)
4. **ESCP**-ийн хүрээнд дээр байгаа нэгдүгээр заалтад дурдсан Монгол улсын Яам, салбар нэгжүүд нь зарим арга хэмжээ, ажлуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй.
5. Энэхүү **ESCP**-д тусгасан бараа материалын нийлүүлэлт, хэмжилтийн ажлын хэрэгжилтийн тайланг Төслийн удирдах нэгж Банкинд өгөх ба тус ажлын явц, эцэслэгдсэн байдалд Банк хяналт тавьж, дүгнэж ажиллана.
6. Монгол улс тус банктай харилцан зөвшилцсөний дагуу энэхүү **ESCP**-ийг боловсруулах ба Төслийн хэрэгжилтийн явцад Төсөлд гарсан өөрчлөлттэй холбоотой уян хатан зохицуулалт хийж, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах, эсвэл **ESCP**-г тухай бүрд нь өөрчлөх боломжтой. Тус төлөвлөгөөний өөрчлөлт нь Монгол Улс нь Банк хоорондын албан бичгээр баталгаажих ба шинэчилсэн **ESCP**-г нэн даруй нийтэд ил болгоно.
7. Төсөлд өөрчлөлт ороход урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал, эсвэл Төслийн хэрэгжилтийн үеэр төслийн биелэлтэнд өөрчлөлт учруулсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийн нөлөө, авто замын ачаалал, бүтээн байгуулалтын шатанд байгаль орчинд үзүүлэх нөлөө, төслийн үйл ажиллагааны шат дахь хөдөлмөрийн хүч зэргийг багтаасан эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэхийн тулд Монгол Улс нь эдгээр арга хэмжээ, ажлуудыг хэрэгжүүлэхээр нэмэлт санхүүжилт олгох болно.

БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ХЭМЖИЛТИЙН АЖЛУУД		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА
ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ			
A	ТОГТМОЛ ТАЙЛАГНАХ: Төслийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал (ESHS)-ын биелэлт хяналтын тайланг тогтмол боловсруулж, Банканд илгээнэ. Үүнд ESCP-ийн хэрэгжилтийн явц, оролцогч талуудын хариуцсан ажлууд, санал, гомдлын механизмд шаардсаны дагуу E&S-ийн бичиг баримтуудын (ESMP, SEP, LMP, RAP, ESMF, RPF г.м) боловсруулалт, хэрэгжилтийг оролцуулна.	Төслийг хэрэгжүүлэх явцад ISR (Төсөл хэрэгжилтийн тайлан)-ийн тайлангийн хамт 6 сар тутамд.	Төслийн удирдах нэгж (ТУН)
B	ОСОЛ: Төсөлтэй холбоотой аливаа осол гарсан тохиолдолд Банкнд нэн даруй мэдэгдэнэ. Ингэхдээ тухайн ослын талаар хангалттай нарийн мэдээлэл, хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа яаралтай арга хэмжээний талаар тайлбарлаж, гэрээ гүйцэтгэгчид болон хяналтын нэгжүүдээс өгсөн холбогдох мэдээллийг өгнө. Үүнтэй зэрэгцээд Банкны хүсэлтээр тухайн ослын талаар тайлан боловсруулж, ижил төрлийн нөхцөл байдал үүсгэхгүй байхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг санал болгоно.	Осол гарсныг мэдсэн даруйдаа.	ТУН
C	ГҮЙЦЭТГЭГЧИЙН САР ТУТМЫН ТАЙЛАН: Банктай хийсэн худалдан авалтын стандартын бичиг баримтад заасан ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гүйцэтгэгч нь сар бүр төслийн удирдах нэгжид хяналтын тайлан хүргүүлэх үүрэгтэй. Хэрэв шаардлагатай гэвэл ирүүлсэн хүсэлтийн дагуу уг сар тутмын тайланг Банк зээлдэгчээс авах талаар ажлын хэсэг тусгах боломжтой.	Төслийг хэрэгжүүлэх явцад сар бүр.	ТУН
ESS 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ, НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ			
1.1	БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ: Байгаль орчин, нийгмийн удирдлагын эрсдэлийн удирдлагыг дэмжих зорилгоор ТУН-ээс ESF (Байгаль орчин, нийгмийн хүрээ)- болон холбогдох хэрэглүүрүүдэд уялдуулах ажлыг хариуцсан байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүдийн чадварлаг бүрэлдэхүүнтэй, шаардлагад нийцсэн байгууллагын бүтцийг боловсруулна.	E&S-ийн эрсдэлийн удирдлагыг дэмжүүлэхээр 90 хоногийн хугацаанд төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан нэгж нь шалгуурт нийцсэн ажиллах хүчээр бүрдсэн байгууллагын нэгж бүрдүүлнэ.	ТУН

БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ХЭМЖИЛТИЙН АЖЛУУД		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА
1.2	<p>БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ: Төсөлд зориулж боловсруулсан Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө, нөлөөллийн үнэлгээг Банканд хүлээн зөвшөөрөгдөхөөр шинэчлэх, батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	Төслийн үнэлгээнээс өмнө боловсруулж, бүтээн байгуулалтын хэрэгжилтийн болон ашиглалтад орох шатнаас өмнө гүйцэтгэнэ.	ТУН
1.3	<p>МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭРЭГСЭЛ, ХЭРЭГЛҮҮРҮҮД: Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (ESF)-ний ESSs (Байгаль орчин, нийгмийн стандарт)-ын хүрээнд ESMP, SIA дээр тодорхойлсон эрсдэлүүдийг бодолцон боловсруулсан Абестын удирдлагын төлөвлөгөө, Замын ачааллын удирдлагын төлөвлөгөө (TMP), Хөдөлмөрийн удирдлагын журам, Байгаль орчны код (ECOP), Байгаль орчны тодорхой арга хэмжээнүүд, Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (RP), Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (RPF), Оролцогч талуудын хийх ажлуудын төлөвлөгөө (SEP) зэрэг Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (ESMP)-ний баримт бичгүүд.</p> <p>Санал болгосон ажлуудыг Төсөлд зориулан боловсруулсан ESMF-тэй уялдуулах байдлаар харуулж, улмаар ESMP-ийн ажлуудыг шаардлагын дагуу Дэлхийн Банканд хүлээн зөвшөөрөгдөхөөр боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх.</p>	Төслийг хэрэгжүүлэх болон ашиглалтад орсны дараах шатанд тухай бүрд шинэчилнэ.	ТУН
1.4	<p>ГҮЙЦЭТГЭГЧИЙН МЕНЕЖМЕНТ: Холбогдох E&S баримт бичиг, эсвэл төлөвлөгөө, Хөдөлмөрийн удирдлагын журам зэрэг ESCP-ийн холбогдох хэсгүүдийг ESHS-ийн гүйцэтгэгчидтэй байгуулсан худалдан авалтын баримт бичгүүдийн шалгуурт нэгтгэж гүйцэтгэгчтэй хийсэн гэрээ тус бүрд ESHS-ийн шаардлагыг гүйцэтгэгч биелүүлэх ёстой.</p>	Худалдан авалтын бичиг баримтуудыг боловсруулахаас өмнө болон Төслийн хэрэгжилтийн турш.	ТУН
1.5	<p>Зөвшөөрөл, зөвшилцөл, эрх: Төслийн байршилын сонголт, Ус, хөрс хамгаалах, Усны нөөцийн тусгай хамгаалалтын бүсүүдийг тогтоох, Зам хаах гэх мэт Төсөлд хамаарах гэрчилгээ, зөвшөөрөл, тусгай эрхийг холбогдох төрийн байгууллагуудаас авч, бүх шаардлагыг төслийн хэрэгжилтийн хугацаанд биелүүлж, дагаж мөрдөнө.</p>	Худалдан авалтын бичиг баримтуудыг боловсруулахаас өмнө болон Төслийн хэрэгжилтийн туршид.	ТУН

БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ХЭМЖИЛТИЙН АЖЛУУД		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА
ESS 2: ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ			
2.1	ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ: Төсөлд зориулан боловсруулсан Хөдөлмөрийн Менежментийн Журам (ХМЖ)-ийг шинэчилж, хэрэгжүүлж үүний дагуу гомдол барагдуулах механизмыг мөрдөж ажиллана.	Төслийн бүтээн байгуулалт, ашиглалтад орсны дараах шатанд	ТУН
2.2	ТӨСЛИЙН АЖИЛЧДЫН ГОМДЛЫГ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ: Байгаль орчин, нийгмийн хариуцлагын стандартад нийцэхүйцээр ХМЖ-ын дагуу төслийн ажилчдад зориулсан гомдол барагдуулах механизм боловсруулж, тогтвортой хэрэгжүүлэх.	Төсөл дээр ажиллагчдыг ажиллуулж эхлүүлэхийн өмнө болон ашиглалтад орсны дараа тогтвортой мөрдөнө	ТУН
2.3	АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА: ESMP-д заасны дагуу ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа (АБААЗ) боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.	Төслийн үнэлгээг хийхээс өмнө боловсруулж бүтээн байгуулалтын үеэр болон ашиглалтад орсны дараа тогтвортой мөрдөнө.	ТУН
ESS 3: НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ БА ОРЧНЫ БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, МЕНЕЖМЕНТ			
3.1	ЭЛЕКТРОН ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: Электрон хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.	/	/
3.2	НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ БА ОРЧНЫ БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, МЕНЕЖМЕНТ: ESMP (байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө)-ийн дагуу боловсруулсан эрчим хүч, усны зохистой хэрэглээний төлөвлөгөөг бэлдэж, хэрэгжүүлэн мөрдөнө. ESMP-ийн хүрээнд асбест, хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, шинэчлэн, баталж, хэрэгжүүлнэ.	Төслийн хэрэгжүүлэлт, үйл ажиллагааны шатанд	Банкны дэмжлэгтэйгээр ТУН
ESS 4: ОРОН НУТГИЙН ОРШИН СУУГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
4.1	ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ESMP-д тусгасны дагуу Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулж батална. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төв нь голлох үүрэг гүйцэтгэнэ.	Төслийн бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө боловсруулж, хэрэгжүүлэлтийн явцад тасралтгүй шинэчлэн мөрдөнө.	ТУН Нийслэлийн авто замын хөгжлийн газар

БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ХЭМЖИЛТИЙН АЖЛУУД		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА
4.2	ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ: Төслийн хүрээнд хийх ажлуудтай холбоотой орон нутгийн иргэдэд учирч болзошгүй хүндрэл, эрсдэлийг тодорхойлж, сэргийлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж, мөрдөнө.	Төслийн бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө боловсруулж, хэрэгжүүлэлтийн явцад болон ашиглалтад орсны дараа тасралтгүй шинэчлэн мөрдөнө.	ТУН
4.3	ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ: Асбестын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, шинэчлэн, баталж, хэрэгжүүлнэ.	Төсөл хэрэгжүүлэх шатанд	ТУН
4.4	GBV (ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ) БОЛОН SEA (БЭЛГИЙН ДАРАМТ)-ИЙН ЭРСДЭЛ: Туслан гүйцэтгэгчийн гэрээнд GBV/SEA-ийн дагуух үүрэг, зарчмыг тодорхой тусгах	Тендерийн өмнө	Монгол Улсын Эрчим Хүчний Яам
4.5	ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ҮЕ ДЭХ GBV (ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ) БОЛОН SEA (БЭЛГИЙН ДАРАМТ)-ИЙН ЭРСДЭЛ: Төсөл хэрэгжүүлэлтийн явцад тулгарч болзошгүй GBV болон SEA-ийн эрсдэл, үр дагаварыг арилгахад хүрэлцэхүйц санхүүгийн нөөц байлгах	Төслийн бүтээн байгуулалтаас өмнө шаардлагатай арга хэмжээг авна. Төслийн хэрэгжүүлэлтийн шатанд тогтвортой үргэлжлүүлнэ.	Монгол Улсын Эрчим Хүчний Яам, ТУН
4.6	АЮУЛГҮЙН АЛБАНЫ АЖИЛТАН: Галт зэвсэг ашиглахгүй.	/	/
ESS 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, ХОРИГ БОЛОН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ [
5.1	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: ESS5-ийн дагуу нөхөн сэргээх дэд ажиллагааг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд багтаан баталж, хэрэгжүүлнэ.	Төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө шаардлагатай нөхөн олговрыг олгоно.	Монгол Улсын Эрчим Хүчний Яам, ТУН
5.2	Нүүлгэн шилжүүлэлтийн бодлого (НШБ): Төслийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан нүүлгэн шилжүүлэлтийн бодлогыг баталж, хэрэгжүүлнэ (дэд бүлэг 1.2). Цаашдаа нүүлгэн шилжүүлэлтэй холбоотой арга хэмжээ хэрэгжүүлэхийн өмнө банкны шаардлагад нийцэхүйцээр НШБ-г баталж, хэрэгжүүлнэ.	Төслийн хүрээнд 1.2-р дэд бүлэгт заасан ажлуудыг гүйцэтгэхээс өмнө НШБ-ийг эртнээс боловсруулж бүрэн хэрэгжүүлэх бөгөөд шаардлагатай нөхцөлд бүрэн нөхөн олговор олгоно.	Монгол Улсын Эрчим Хүчний Яам, ТУН

БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ХЭМЖИЛТИЙН АЖЛУУД		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА
5.3	ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ: Нүүлгэн шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нөхөн олговрын механизмыг тодорхой тусгах бөгөөд нөхөн олговрын хэлбэр болон холбоо барих хаягийг нүүн шилжих шаардлагатай болсон хүмүүст мэдэгдэнэ.	Нүүлгэн шилжүүлэх ажиллагааг эхлэхээс өмнө боловсруулж төсөл хэрэгжүүлэх явцад мөрдөнө.	ТУН
ESS 6: БИОЛОГИЙН ОЛОН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ БОЛОН АМЬД БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ			
6.1	БИОЛОГИЙН ОЛОН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ: [ESMP-д биологийн олон төрөл зүйлд учир болзошгүй хохиролтой холбоотой эрсдэлийг нарийн заах боломжгүй нөхцөлд.]	/	/
ESS 8: СОЁЛЫН ӨВ			
8.1	ГЭНЭТИЙН ОЛЗ: төсөлд зориулан боловсруулсан ESMP-ийн дагуу гэнэтийн олз олдсон тохиолдолд авах арга хэмжээний журмыг баталж, мөрдөнө.	Төслийн үнэлгээнээс өмнө боловсруулж, хэрэгжилтийн явцад мөрдөнө.	ТУН
ESS 10: ХОЛБОГДОХ ТАЛУУД БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
10.1	ХОЛБОГДОХ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ: Төслийн үнэлгээнээс өмнө холбогдох талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний төслийг бэлтгэнэ. ХТТОТ-г шинэчилж, батлан, хэрэгжүүлнэ.	Төслийн үнэлгээнээс өмнө боловсруулж, хэрэгжилтийн явцад болон ашиглалтад орсны дараа мөрдөнө.	ТУН
10.2	ТӨСЛИЙН ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ: ХТТОТ-д заасны дагуу гомдол барагдуулах механизмыг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.	Төслийн үнэлгээнээс өмнө боловсруулж, хэрэгжилтийн явцад болон ашиглалтад орсны дараа мөрдөнө.	ТУН
ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ (СУРГАЛТ)			
CS.1	Байгаль орчин, нийгмийн менежментийн сургалт	ТУН-ын ажилтнууд болон холбогдох төрийн албан хаагчид	Банкны дэмжлэгтэйгээр ТУН
CS.2	Асбестийн менежментийн сургалт	Туслан гүйцэтгэгч, ажилчид, ажлыг удирдагч болон холбогдох төрийн албан хаагчид	Банкны дэмжлэгтэйгээр ТУН